

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Дархан-Уул аймгийн орон нутгийн
удирдлагатай хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 9-р сарын 7

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлыг сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 7-нд Дархан-Уул аймгийн орон нутгийн удирдлага, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 16 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
Улс орны хөгжлийн дүн шинжилгээний талаар санал (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)	Боломж: <ul style="list-style-type: none">• Улс орон өдий зэрэгт хүрэхийн тулд олон саад бэрхшээлийг даван туулсан. Олон салбарт ахиц гарахад гадаад, дотоод хүчин зүйлс нөлөөлсөн ч олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын байгууллагуудаас өгсөн туслалцаа, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг гадаад хүчин зүйлс давамгайлсан. Өмнө нь улс орны гадаад харилцаа, тэр дундаа эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр сайн хөгжөөгүй байсан. Олон улсын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрээр олон боломж гарч байсан ч тэдгээрийг хэр сайн ашигласан бэ гэдэг нь эргэлзээтэй.• Улс орны эрдэс баялаг эдийн засгийг дэмжсэн бөгөөд энэ чиглэлээр олон сургамж мөн авсан.• Том хоёр хөрш орны дунд оршдог нь тэдний зах зээлд нэвтрэх боломжийг бидэнд олгодгоороо том боломж.• Дарханд дэд бүтэц сайн хөгжсөн учир боловсруулах үйлвэрүүдийг байгуулах боломжтой.• Малын генетикийн санг байгуулж байгаа бөгөөд үүнийг мал аж ахуйг хөгжүүлэхэд ашиглах боломжтой.• Хүн ам цөөн байгаа нь нэг талаараа бодлого эдгээр цөөн хүн амд хүрэх боломжийг олгодог.

- Дэлхийн Банкны санхүүжилттэй хэрэгжсэн хуучин төслүүд орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох иргэдийн мэдлэгийг дээшлүүлсэн.

Сорилт:

Макро эдийн засаг, төсвийн байдал

- Макро эдийн засгийн тогтвортой байдал сул байгаа бөгөөд үүнд 2 хүчин зүйлс нөлөөлж байна: 1. Төвлөрөл саарч, хэт ардчилал бий болж байгаа нь Монголд тохиромжгүй. Үүний оронд Монголын нөхцөл байдалд илүү тохирсон ардчиллын онцгой хэв маягийг бий болгох хэрэгтэй.
- Мөн бүс нутгийн хөгжлийн стратегийг бүсүүдийн онцлог шинж чанар, харьцангуй давуу талыг ашиглах боловсруулах хэрэгтэй. Үүнийг хийхийн тулд санхүүгийн дэмжлэг болон улс орны онцлогийг харгалзан үзсэн бүтцийн шинэчлэл хэрэгтэй.
- Төсвийн жил хуанлийн жилтэй ижилхэн байгаа нь Монгол шиг бүтээн байгуулалт, барилга, хөдөө аж ахуйн сезон богинотой оронд тохиромжгүй. Хуанлийн жилээр явснаар энэ богино хугацааг алдаж, төслүүд хугацаа алдан хожимдоход хүрдэг.
- Орон нутгийн хөгжлийн сангаас тухайн жилийн төсвийн төсөөллийг хэзээ ч сөргөөр өгдөггүй нь олон талуудыг хөндөж байна.
- Эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг зөв тооцоогүй, тэдгээрийг шинэчлэх шаардлагатай.

Засаглал, улс төр

- Засгийн газрын зүгээс тогтвортой бодлого авч явуулахгүйгээс болж улс орны хөгжлийн урт хугацааны алсын харааг боомилж байна. Улс төрийн сонгуулийн мөчлөг богино байгаагаас болж богино хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг явуулж, улс төрийн тогтворгүй байдалд хүргэж байна. Засгийн газрын бодлого тогтворгүй байгаагаас болж үр дүнг хадгалан авч үргэлжлүүлдэггүй. Монгол урт хугацааны хөгжлийн бодлогоын баримт бичгүүд байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт муу байна.
- Улс төрийн намууд нь улс орныг манлайлан, удирдах чадвар бүхий хөгжлийн хувьд боловсорч гүйцсэн институци биш байгаа тул тэд боловсорч гүйцэн, гудамжинд бослого зохион байгуулахын оронд бодлогын мэтгэлцээн, хэлэлцүүлэг хийх хэрэгтэй. Улс орон улс төрөөс хэтэрхий их хамааралтай болсон бөгөөд бодлогыг зарчимд суурилан боловсруулдаггүй, харин богино хугацааны сонгуулийн амлалтанд суурилдаг. Гадаадын шууд хөрөнгө оруулалтанд ирээдүйн тодорхой, эрсдэлгүй байдал чухал байдаг тул Засгийн газрын тогтворгүй байдал ГШХО-д нөлөөлж байна. Нэг ч Засгийн газар хоёр удаа дараалан томилогдож байгаагүй.
- Төрийн албаны тогтвортой байдал мөн асуудалтай. Төрийн албан хаагчид солигдон, шинэ хүмүүсийг дахин сургах бэлтгэх хэрэгтэй байдаг нь төрийн албын хөгжилд чадар тушаа болж байна.

- Орон нутгийн засгийн газруудын бие даасан, өөрийн удирдлагыг хөгжүүлэх тал дээр дутагдалтай байсан. Тэгш байдлын зарчмаар орлогыг тухайн орон нутагтаа үлдэж, иргэдийн амьжиргааг сайжруулахад зарцуулагдахгүй байна.
- Уул уурхайн салбараас орж ирж буй баялгийн хуваарьлалтын тэгш бус байдлаас улмаас ядуурал асуудал болж байна.
- Улс орны хүн ам нийт газар нутгаар хэтэрхий тархай байхгүйн тулд засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг дахин харах хэрэгтэй.
- Хэвлэл мэдээлэл, тэр дундаа сошиал хэвлэлээс гарч ирж болзошгүй аюулыг бууруулахын тулд хэвлэл мэдээлэлд цензур тавих хэрэгтэй.
- Олон нийтийн үзэл бодол хэтэрхий хоёр туйл руу туйлшрах хандлагатай болсон тул иргэдийн улс төрийн шийдвэр гаргах, санхүүгийн зах зээл, нийтийн үйлчилгээ зэргийн талаар мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй. Жишээ нь, Засгийн газар үнэгүй үйлчилгээ үзүүлж, хувийн хэвшил үнэ төлбөртэй үйлчилгээ үзүүлэх ёстой гэсэн буруу ойлголт байна.

Хувийн хэвшлийн хөгжил

- Хувийн хэвшлийг хөгжүүлэх нь чухал ч гэсэн бичил, өрхийн бизнесийг хөгжүүлэхийн тулд стандарт, хэм хэмжээний шаардлагыг бууруулах хэрэгтэй.
- Засгийн газрын үр дүнтэй оролцоо байхгүй байна. Засгийн газар илүү бага оролцож, илүү их дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- Хууль эрх зүйн орчин, бодлогудыг тогтвортой байлгаж, хөрөнгө оруулагч нарт боломж олгох хэрэгтэй.
- Татвар нь бизнес эрхлэгчдэд том дарамт болж байгаа тул татварын хувь хэмжээг бууруулах (нэг оронтой тоонд хүргэх) эсвэл нийгмийн даатгалын хувийг санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авах боломжтой.
- Хувийн хэвшил хумигдан, зээлийн хүү өндөр байна.
- Жижиг хөрөнгө оруулагч нарыг татахын тулд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хэрэгтэй.

Ажил эрхлэлт, ажлын байр

- Дэд бүтцийн санхүүжилтэд нэлээд их дэмжлэг үзүүлсэн боловч ажлын байр бий болгоход чиглэсэн санхүүжилт төдийлөн их хийгдээгүй.
- Монголчууд үнэгүй, хавтгайрсан халамж авч сурч байгаа бөгөөд энэ сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй. Хүмүүс ажилд орохын оронд халамж аван амьдарч байгаа нь хөгжлийг боомилж байна.
- Хөдөлмөрийн үнэлэмж, баялгийн хуваарьлалт тэгш бус байна. Бизнесийн эзэд өөрсөддөө илүү их ашгийг авдаг.
- Хүн амын 30 хувь л тогтвортой ажил эрхэлж байна. Их дээд сургууль төгсөгч залуусын ихэнх нь ажилгүй байгаа энэ үед залуусын дундах ажилгүйдэл том асуудал болж байна. Сургалт, техник мэргэжлийн боловсрол олгох курсууд байгаа хэдий нь ажлын байр хангалттай биш байна.

	<ul style="list-style-type: none"> • Хувь хүний орлогоос өндөр татвар авч байгаа нь эргээд нийгмийн халамжийн төлбөрт төлөхөөр хийгдэж байгаа. Үүний оронд татварыг ашиглан ажилчдаа орон сууц олгоход ашиглавал, түүний урт хугацааны тогтвортой ажлын байр, орон сууцны асуудлыг шийднэ.
<p>ДБГ-ийн стратеги, түншлэлийн талаар санал</p>	<p>Салбарууд:</p> <ul style="list-style-type: none"> • Одоогийн эдийн засгийн хямралыг давахад гол анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Эдийн засгийн суурь сэргээд ирэхлээр бусад салбаруудыг мөн хөгжүүлэх боломжтой болно. • Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах салбаруудыг дэмжих хэрэгтэй. • Мал аж ахуй – Түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүнийг гаргах, цаашлаад экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх. Бүтээгдэхүүнээ олон улсын зах зээл дээр гаргахын тулд уламжлалт, орчин үеийн технологийг хослуулан ашиглах боломжтой. Хөдөө аж ахуйн салбар дахь нэмүү өртөг шингээхэд судлаач, шинжлэх ухааны хүмүүсийн дэмжлэгийг авбал хэрэгтэй. Жимс, эрдэнэ шиш, эмийн ургамал зэргийн шинэ сортыг гаргах боломжтой. Зүгээр үр тариа хураан авахаас илүүтэйгээр имс жимсгэнэ, эмийн ургамлыг зохицуулах. Фермер, малчдын амьжиргааг дээшлүүлж, үр дүнд хүрэх болвол хоршоодыг байгуулах нь зүйтэй. • ЖДҮ-д чиглэсэн олон жижиг төслүүд хэрэгждэг нь тэд төслийг хаах үед урт хугацаанд авч явахад хүндрэлтэй байдаг. Бараа бүтээгдэхүүн худалдан авах орон нутгийн зах зээл хязгаарлагдмал байна. • Тээвэр, логистик - Монгол Улс далайд гарцгүй тул зам тээвэр, логистикоос их хамааралтай. Олон улсын хөгжлийн түншүүд энэ чиглэлээр хамтран ажиллаж болно. Монгол бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд төмөр замыг хөгжүүлэх. • Хүний хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй. Боловсролын салбарт бүтцийн өөрчлөлт хэрэгтэй бөгөөд багш нарын хөгжлийг цаашид анхаарах хэрэгтэй. Хүн амын өсөлтийг дэмжихийн тулд Дарханд их дээд сургуулиудыг дэмжих хэрэгтэй. • Эрүүл мэнд, тэр дундаа нийгмийн эрүүл мэндийн асуудлуудыг шийдвэрлэн, Монголд нийгмийн эрүүл мэндийн санхүүжилт, хүрээг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах хэрэгтэй. Хууль эрх зүйн орчныг сайжруулан, цахим эрүүл мэндийн тогтолцоог цаашид илүү сайжруулан, хөгжүүлэх хэрэгтэй. • Банк, санхүүгийн салбар – хүү багатай банкны зээлийг бий болгох орчныг бий болгох, санхүүгийн зах зээл, санхүүгийн эх үүсвэрүүдийн олон нийтийн хүртээмжийг улам сайжруулах. Санхүүжилт дутмаг, зээлийн хүү өндөр байгааг харгалзан гадны банкнуудыг зах зээлд орох эрхийг нээх хэрэгтэй. • Хөдөлмөр эрхлэлтийг цаашид хөгжүүлэх. Ингэхдээ ажил олдоход хэцүү байдаг залуус болон 45-с дээш насныханд төвлөрөх хэрэгтэй. Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулахын тулд ЖДҮ-үүд болон аж үйлдвэрүүдийг дэмжих. Ажил эрхлэлтийг дэмжин олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэн, тоног төхөөрөмж худалдан авахад хүрэлцэхүйц болгох хэрэгтэй.

	<p>Арга зам, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> Төслийн хэрэгжилтийн хугацаа дууссаны дараа үйл ажиллагаа, үр дүн нь цаашид тогтвортой үлдэж, тогтоход анхаарах.
Дэлхийн Банкны оролцооны талаар өгсөн санал	<ul style="list-style-type: none"> READ төслөөс цааш цахим номын санг үргэлжлүүлэн дэмжих. Биет болон биет бус соёлын өвийг хадгалах тал дээр дэмжлэг үзүүлэх. Орон нутгийн олон иргэдийн амьжиргааг дэмждэг уурхай байрладаг Шарын гол сум рүү хүрэх замыг барихад дэмжлэг үзүүлэх.

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

- Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	12	75%
— Боловсрол	9	56%
— Төрийн удирдлага/шинэтгэл	7	44%
— Хүнсний аюулгүй байдал	7	44%
— Эрүүл мэнд	5	31%
— Гадаадын хөрөнгө оруулалт	5	31%
— Худалдаа, экспорт	5	31%
— Авлигатай тэмцэх	4	25%
— Хөдөөгийн хөгжил	4	25%
— Хотын хөгжил	4	25%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	3	19%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	3	19%
— Эдийн засгийн өсөлт	3	19%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	2	13%
— Ус, ариун цэврийн байгууламж	2	13%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	2	13%
— Санхүүгийн зах зээл	1	6%
— Нийгмийн хамгаалал	1	6%
— Байгалийн нөөцийн удирдлага	0	0%
— Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	0%
— Эрх тэгш боломжоор хангах	0	0%
— Зам, тээвэр	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Бусад	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	11	69%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	9	56%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	8	50%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	7	44%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	2	13%
Бүгд чухал	2	13%